



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

Г Хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан Г
журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасыг анхдагч зах зээл дээр санал болгох, худалдах тухай журам”-ын 4 дүгээр зүйлд дор дурдсан агуулга бүхий 25¹ дэх хэсэг, 28 дэх хэсгийн 2¹ дэх заалт, 34 дүгээр хэсгийг тус тус нэмсүгэй:

1/ 4 дүгээр зүйлийн 25¹ дэх хэсэг:

“4.25¹-д “Үнэт цаас гаргагчийн зах зээлийн үнэлгээ болон хэрэгжүүлэх үйл ажиллагааны цар хүрээ, улс орны хэмжээний томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх боломжтой зэрэг эдийн засгийн ач холбогдлыг харгалзан Хороо энэ журмын 4.25-д заасан хэмжээнээс өөрөөр тогтоож болно”;

2/ 4 дүгээр зүйлийн 28 дахь хэсгийн 2¹ дахь заалт:

“4.28.2¹. Үнэт цаас гаргагчийн зах зээлийн үнэлгээ болон хэрэгжүүлэх үйл ажиллагааны цар хүрээ, улс орны хэмжээний томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх боломжтой зэрэг эдийн засгийн ач холбогдлыг харгалзан Хороо энэ журмын 4.28.2-д заасан хэмжээнээс өөрөөр тогтоож болно”;

3/ 4 дүгээр зүйлийн 34 дэх хэсэг:

“4.34. Энэ журамд заасан стратегийн хөрөнгө оруулагч гэдгийг үнэт цаас гаргагчтай хамтран ажиллах гэрээ байгуулсан, нийт зарласан хувьцааны таваас доошгүй хувийг хөрөнгө оруулж эзэмшсэн, хувьцаагаа хоёрдогч зах зээлд Хорооноос тогтоосон тодорхой хугацаанд худалдахгүй байх үүрэг хүлээсэн иргэн, хуулийн этгээдийг ойлгох бөгөөд түүнийг тухай бүр Хорооноос тогтооно.”.

2 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасыг анхдагч зах зээл дээр санал болгох, худалдах тухай журам”-ын 2 дугаар зүйлийн 6 дахь заалтын “эсэхийг” гэсний дараа “Компанийн тухай хуулийн 38.8-д заасны дагуу шийдвэрлэж, энэ тухай” гэж, 4 дүгээр зүйлийн 22 дахь заалтын “бөгөөд” гэсний дараа “энэ журмын” гэж, тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасыг анхдагч зах зээл дээр санал болгох, худалдах тухай журам”-ын 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 5, 5.1 дэх заалтууд, 5 дахь хэсгийн 2 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалт, 3 дахь хэсгийг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/ 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

“1.3. Үнэт цаасны танилцуулгад анх гаргахаар төлөвлөж, хөрөнгийн биржид арилжаалахаар байршуулсан үнэт цаасыг анхдагч зах зээл дээр бүрэн арилжиж дуусах хүртэл тухайн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арижааг эхлүүлэхийг хориглоно.”;

2/ 2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 5, 5.1 дэх заалтууд:

“2.3.5. Улс орны эдийн засгийн тогтвортой байдал, өсөлт, хөгжилд бодитой хувь нэмэр оруулахуйц үйлдвэрлэл, үйлчилгээний төсөл хэрэгжүүлэхээр байгуулагдсан, төсөл нь хэрэгжих шатандаа байгаа, өөрөөр хэлбэл борлуулалт хийж эхэлж байгаа буюу эхлээгүй байгаа компанид энэ журмын 2.3.1-2.3.4-г заасан шаардлага хамаарахгүй бөгөөд ийм компани нь дараахь шаардлагыг хангасан байна.”;

“2.3.5.1. Төсөл цаашид тогтвортой хэрэгжихэд шаардлагатай санамж бичиг, гэрээ, хэлцлийг бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагч нартай байгуулсан.” ;

3/ 5 дахь хэсгийн 2 дахь заалт:

“2.5.2. Компанийн нийт гаргасан хувьцааны 70-аас дээшгүй хувийг нэг этгээд дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэггүй байх.”

4/ 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалт:

“4.5.3. Үнэт цаасны товч болон дэлгэрэнгүй танилцуулгыг хэвлэл мэдээллийн болон зар сурталчилгааны арга хэрэгслээр нийтэд хүргэх бэлтгэл хангасан байх.”

5/ 4 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“4.3. Үнэт цаасны танилцуулгыг үнэт цаас гаргагч болон андеррайтер нь дараахь арга, хэлбэр, давтамжтайгаар нийтэд танилцуулна.”

4 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасыг анхдагч зах зээл дээр санал болгох, худалдах тухай журам”-ын “1.3, 1.4, 1.5, 1.6, 1.7, 1.8” гэсэн дугаарыг “1.2, 1.3, 1.4, 1.5, 1.6, 1.7” гэж, 2.18.12, 4.21, 4.30, 7.8.1, 8.4, 8.10, 8.18-т заасан “Компанийн тухай хуулийн 27.7, 39, 54.2, 56.4, 55, 58.1, 66.3 дугаар” гэснийг “Компанийн тухай хуулийн 27.8, 38, 54.4, 55, 54, 57.1, 65.4 дүгээр” гэж, 4.3.1-ийн “Зар сурталчилгааны 3-аас доошгүй” гэснийг “3-аас доошгүй хэвлэл мэдээлэл, зар сурталчилгааны” гэж, 4.20-ын “тогтоосон үнэ” гэснийг “тогтсон үнэ” гэж, 4.25-ын “тогтсон үнээр болон дуудлагын худалдааны аргаар ..., захиалга авах аргаар” гэснийг “тогтоосон үнээр болон үнэ хаялцуулан дуудлагаар худалдах аргаар ..., захиалгын бүртгэл хийх аргаар” гэж, 4.28.2-т “Үнэт цаасны” гэснийг “Энэ журамд өөрөөр заагаагүй бол үнэт цаасны” гэж, 5.1-ийн “30 хоногийн” гэснийг “10 хоногийн” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасыг анхдагч зах зээл дээр санал болгох, худалдах тухай журам”-ын 2.3.4 дэх заалт, 2.3.5.1 дэх заалт, 2.5.5 дахь заалт, 2.20-д заасан “2.5.5, 2.8.3” дэх заалт, 7.5-д заасан “Хороо энэ үндэслэлийг” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Журамд нэмэлт, өөрчлөлтийг оруулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар/Д.Нямцэрэн/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН